



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/70/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**НОГООННУУР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ш.РАЯ ТАНАА**

2022.02.25 № 042

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>252,378,848.00</u>	<u>282,726,846.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	252,378,848.00	282,726,846.00
354	Хангамжийн материал	228,478,848.00	249,586,846.00
35410	Бичиг хэргийн материал	174,700.00	62,350.00
35420	Аж ахуйн материал	165,534,437.00	172,196,537.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	3,007,251.00	579,094.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	16,370,445.00	31,722,130.00
35470	Бусад хангамжийн материал	43,392,015.00	45,026,735.00
35500	Биологийн хөрөнгө	-	-
35600	Мал амьтад	23,900,000.00	33,140,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,695,956,731.37</u>	<u>1,689,637,604.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,695,956,731.37	1,689,637,604.14
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,639,802,731.37	1,633,758,604.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,713,181,660.38	1,713,181,660.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(181,664,358.43)	(227,042,726.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,837,186.00	68,859,826.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,286,888.80)	(19,174,940.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,499,508.00	61,452,915.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,374,674.78)	(31,675,881.78)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	8,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	69,429,827.00	69,429,827.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(69,429,827.00)	(69,429,827.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	57,610,299.00	60,157,752.00
393	Биет бус хөрөнгө	56,154,000.00	55,878,999.96
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(275,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,604,000.00	55,604,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,948,335,579.37</u>	<u>1,972,364,450.14</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>12,399,291.97</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,399,291.97	-
413	Өглөг	12,399,291.97	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,399,291.97	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,935,936,287.40</u>	<u>1,972,364,450.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,935,936,287.40	1,972,364,450.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	465,200,088.00	465,200,088.00
51101	Өмч: - төрийн	465,200,088.00	465,200,088.00
512	Хуримтлагдсан үр дүн	(431,042,325.48)	(394,614,162.74)
51210	Өмнөх үеийн үр дүн	(431,042,325.48)	(431,042,325.48)

51220	Тайлант үеийн үр дүн	-	36,428,162.74
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,901,778,524.88	1,901,778,524.88
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,948,335,579.37</u>	<u>1,972,364,450.14</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,744,427,207.00	1,761,309,447.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,530,997.00	20,360,190.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,530,997.00	20,360,190.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,530,997.00	20,360,190.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,080,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,530,997.00	17,280,190.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,731,896,210.00	1,740,949,257.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,684,312,046.00	1,691,795,153.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	19,864,046.00	48,571,653.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,664,448,000.00	1,643,223,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,231,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,231,104.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,584,164.00	39,923,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,584,164.00	39,923,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,806,739,195.19	1,723,594,284.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,806,739,195.19	1,723,594,284.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,761,827,755.19	1,679,518,244.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,317,425,011.00	1,277,345,228.03
210101	Үндсэн цалин	1,155,411,511.00	1,169,417,145.03
210104	Урамшуулал	121,173,400.00	67,087,983.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,840,100.00	40,840,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,574,701.97	174,145,000.00
210201	Тэтгэврийн даатгал	117,204,091.97	122,546,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,853,800.00	12,899,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,918,110.00	10,319,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,370,700.00	2,579,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,228,000.00	25,799,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,773,800.00	27,957,150.00
210301	Гэрэл, цахилгаан	6,527,600.00	6,968,000.00
210302	Түлш, халаалт	38,246,200.00	20,989,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,432,825.00	6,613,480.00

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	1,601,000.00	737,150.00
210402	Тээвэр, шатахуун	1,417,500.00	2,206,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,436,900.00	1,806,100.00
210404	Ном, хэвлэл	329,600.00	353,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,647,825.00	1,509,780.00
2105	Нормативт зардал	107,519,089.00	109,825,005.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	508,800.00	658,900.00
210502	Хоол, хүнс	97,179,989.00	106,010,805.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,830,300.00	3,155,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар		1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,222,800.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	2,222,800.00	140,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,500.00	953,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,500.00	353,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,004,028.22	81,538,431.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		18,488,801.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,221,138.00	4,549,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,782,890.22	58,500,280.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,911,440.00	44,076,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,313,550.00	44,076,040.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,313,550.00	44,076,040.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,597,890.00	-
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,597,890.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(62,311,988.19)</u>	<u>37,715,162.74</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,287,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,287,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,287,000.00)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(62,311,988.19)</u>	<u>36,428,162.74</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын өруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь өрөлдөөний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(431,042,325.48)		1,935,936,287.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин үнэлгээний үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(431,042,325.48)		1,935,936,287.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, буурагт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өмг, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн					
C08	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(431,042,325.48)		1,935,936,287.40
D01	2019 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(431,042,325.48)		1,935,936,287.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин үнэлгээний үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(431,042,325.48)		1,935,936,287.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, буурагт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, буурагт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өмг, гарз					
D07	Гадаад наамагч хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			36,428,162.74		36,428,162.74
D09	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(394,614,162.74)		1,972,364,450.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,749,249,839.00	1,692,377,604.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,749,249,839.00	1,692,377,604.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,664,448,000.00	1,643,223,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,664,448,000.00	1,643,223,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,231,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,231,104.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,584,164.00	39,923,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,584,164.00	39,923,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	37,217,675.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	37,217,675.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,743,099,839.00	1,687,481,104.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,743,099,839.00	1,687,481,104.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,661,292,724.00	1,643,405,104.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,309,172,350.00	1,289,962,200.00
210101	Үндсэн цалин	1,147,158,850.00	1,182,034,117.00
210104	Урамшуулал	121,173,400.00	67,087,983.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,840,100.00	40,840,100.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,979,910.00	174,145,000.00
210201	Тэтгэврийн даатгал	112,609,300.00	122,546,400.00

210202	Тэтгэмжийн даатгал	11,853,800.00	12,899,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,918,110.00	10,319,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,370,700.00	2,579,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,228,000.00	25,799,300.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,584,164.00	38,923,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,967,600.00	6,968,000.00
210302	Түлш, халаалт	40,616,564.00	31,955,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,960,300.00	7,879,900.00
210401	Бичиг хэрэг	1,433,000.00	552,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,417,500.00	2,206,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,436,900.00	1,806,100.00
210404	Ном, хэвлэл	1,036,600.00	660,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,636,300.00	2,653,900.00
2105	Нормативт зардал	119,126,700.00	118,624,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	508,800.00	658,900.00
210502	Хоол, хүнс	103,422,000.00	113,758,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,195,900.00	4,207,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар		1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,222,800.00	140,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,222,800.00	140,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,500.00	1,389,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,500.00	789,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,371,000.00	11,340,604.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,771,104.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,371,000.00	4,569,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,807,115.00	44,076,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,209,225.00	44,076,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,217,675.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,991,550.00	44,076,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,597,890.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,597,890.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,150,000.00</u>	<u>4,896,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,150,000.00	4,896,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,150,000.00	4,896,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,150,000.00	4,896,500.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,150,000.00	4,896,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(6,150,000.00)</u>	<u>(4,896,500.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,683,146,500.00	1,683,146,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,683,146,500.00	1,683,146,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,639,070,500.00	1,639,070,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,289,962,200.00	1,289,962,200.00
210101	Үндсэн цалин	1,176,586,500.00	1,182,034,117.00
210104	Урамшуулал	72,535,600.00	67,087,983.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,840,100.00	40,840,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,145,000.00	174,145,000.00
210201	Тэтгэврийн даатгал	122,546,400.00	122,546,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,899,600.00	12,899,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,319,800.00	10,319,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,579,900.00	2,579,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,799,300.00	25,799,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,923,000.00	38,923,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,968,000.00	6,968,000.00
210302	Түлш, халаалт	31,955,000.00	31,955,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,009,500.00	8,009,500.00
210401	Бичиг хэрэг	552,900.00	552,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,206,800.00	2,206,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,806,100.00	1,806,100.00
210404	Ном, хэвлэл	789,800.00	789,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,653,900.00	2,653,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		

2105	Нормативт зардал	118,624,600.00	118,624,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	658,900.00	658,900.00
210502	Хоол, хүнс	113,758,600.00	113,758,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,207,100.00	4,207,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	140,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	140,000.00	140,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,389,800.00	1,389,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	789,800.00	789,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,876,400.00	6,876,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,876,400.00	6,876,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,076,000.00	44,076,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,076,000.00	44,076,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,076,000.00	44,076,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,683,146,500.00	1,683,146,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,643,223,500.00	1,643,223,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,643,223,500.00	1,643,223,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,923,000.00	39,923,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	39,923,000.00	39,923,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	118.00	122.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00
620002	Гүйцэтгэх ажилтан	61.00	65.00
620003	Үйлчлэх ажилтан	42.00	42.00
620004	Гэрээт ажилтан	11.00	11.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	118.00	125.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	75.00	75.00

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35.00	35.00
650010	Гэрээт ажилтан	7.00	14.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,231,104.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,231,104.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,231,104.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,231,104.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,231,104.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,231,104.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,231,104.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,231,104.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн нь: “Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэх” гэсэн зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1806.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.0 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	252,378.8	282,726.8	30,348.0
Үндсэн хөрөнгө	1,695,956.7	1,689,637.6	-6,319.1
Нийт хөрөнгө	1,948,335.6	1,972,364.4	24,028.9
Өр төлбөр	12,399.3	0	-12,399.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,935,936.3	1,973,364.4	36,428.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,948,335.6	1,972,364.4	24,028.9

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 282.7 сая төгрөг болж 30.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 197.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 184.8 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна.

Мал амьтад данс оны эхэнд 23.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 16.3 сая төгрөгөөр малын төлийг орлогоод авч, 7.1 сая төгрөгийн малыг зарлагад гаргасан байна.

Тайлант онд аймгийн БСУГ-аас 1.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоом, 3.0 сав суулгыг туслах үйл ажиллагааны орлогоор авч дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1689.6 сая төгрөг болж 6.3 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 4.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, Сумын орон нутгийн хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 8.0 сая төгрөгийн гүний худаг, БСШУС-ын багцын хөрөнгө оруулалтаар 30.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 7.9 сая төгрөгийн тавилга, аймгийн БСУГ-аас 2.5 сая төгрөгийн номыг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор элэгдлээс бүрэн нөхсөн 79.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4.2 сая төгрөгийн тавилга эд хогшлыг акталж, данс бүртгэлээс хасаж, 128 дугаар тогтоолоор тус сургуулийн дансанд бүртгэлтэй 3.2 сая төгрөгийн дансны үнэтэй, 1.3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмжийг Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт балансаас балансад шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэлд байсан 12.4 сая төгрөгийн НДШ-ийн өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1973.4 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 36.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 1723.6 сая төгрөг, тодотгосон төсөв 1683.1 сая төгрөг байна.

Анх баталсан төсвийг 40.5 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна. Тодруулбал цалингийн зардлыг 117.5 сая төгрөгөөр, НДШ-ийн 15.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.3 сая төгрөгөөр, нормативт зардлыг 147.0 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 0.5 сая төгрөгөөр, үдийн хоолны зардлыг 24.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 45.0 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 15.9 сая төгрөгөөр дутуу суулгаж, нэмэгдэл, урамшлын 72.5 сая төгрөгийн зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийт 1683.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1683.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн 76.6 хувийг цалин, 10.3 хувийг НДШ-ийн зардал, 2.3 хувийг тогтмол зардал, 0.5 хувийг хангамж бараа материалын зардал, 7.0 хувийг нормативт зардал, 0.06 хувийг урсгал засварын зардал, 0.08 хувийг дотоод томилолтын зардал, 0.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 2.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн БСУГ-аас тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд 8.0 сая төгрөгийн, шалгалтын зардалд 0.6 сая төгрөгийн, ариутгалын зардалд 0.6 сая төгрөгийн, нийт 9.2 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1,683.1 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлын батлагдсан төсөв 22.3 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь буюу 2.2 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал зардлыг төлөвлөж зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 4.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд нийт 1643.2 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1643.2 сая төгрөгийн 146 мэдээллийг хугацаанд байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 97.9 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, өр төлбөр, хүнсний материалын үлдэгдэлтэй холбоотой 12.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 1.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Зөвлөмжийн биелэлтийг

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 09-р сарын 77-ны өдрийн 44 тоот албан бичгээр ирүүлжээ.

Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд өглөгийг барагдуулж, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28.3 сая төгрөгийн зөрчил илэрч 7.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 21.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 7.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1,683.1 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлын батлагдсан төсөв 22.3 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь буюу 2.2 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал зардлыг төлөвлөж зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас 4.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" 1.4-т "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Аудитаар 21.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд төсвөөс болон нэмэлт санхүүжилтээр бараа материал худалдан авах, үдийн цай, шуудан холбоо, гэрэл цахилгааны зардалд зарцуулсан нийт 21.2 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.1, 14.3.2, 14.3.3, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж гарсан ажил гүйлгээг тооцооны дансаар бүрэн дамжуулан бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	2	28.3					1	7.1	1	21.2